



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

□ "Таван зуун төгрөг нэмэх" ХЗХ-нд хадгаламж, □
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 15 дугаар зүйлийн 15.3, Хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Таван зуун төгрөг нэмэх" ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Таван зуун төгрөг нэмэх" ХЗХ /Д.Дамдинсүрэн/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН